



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэбулган сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2023/15/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn
Архангай аймаг
2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141
Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn
Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860
Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn
Аудитор Л.Соёлмөнх
Цахим хаяг: Soyolmunkhl@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс:976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2023.03.24 № 144
танай _____ -ны № _____ -т

АРХАНГАЙ АЙМГИЙН
ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ЗАСАГ
ДАРГА Д.МӨНХБАТ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгөл/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль шинэчлэгдсэнтэй холбоотой Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, газрын төлбөр, цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдуулсан хувь хүний орлогын албан татварын орлогыг сумын төсөвт төвлөрүүлдэг болсон байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын засаг дарга нь 2022 оны жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 127 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 79.6 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,890,483.17	1,605,984.66
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	843,774.25	504,122.65
33	АВЛАГА	1,038,319.66	1,065,147.47
35	БАРАА МАТЕРИАЛ	2,004,237.25	22,629.55
36	НӨӨЦИЙН БАРАА	4,152.00	14,085.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	50,139,079.25	15,847,890.13
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	50,139,079.25	15,847,890.13
39200	Биет хөрөнгө	48,588,959.22	15,758,281.63
39300	Биет бус хөрөнгө	1,550,120.03	89,608,500.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	54,029,562.42	17,453,874.80
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	143,256.06	9,955.12
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	143,256.06	9,955.12
41300	Өглөг	143,256.06	9,955.12
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	53,886,306.36	17,443,919.68
51	Засгийн газрын хувь оролцоо	53,886,306.36	17,443,919.68
51100	Засгийн газрын оруулсан капитал	10,725,524.32	2,599,746.48
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	0.00	2,599,746.48
51200	Хуримтлагдсан үр дүн	36,173,245.75	14,808,167.92
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,987,536.28	36,005.28
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	54,029,562.42	17,453,874.80

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	27,966,387.72	7,945,230.49
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,324,592.11	5,629,073.82
110	Орлогын албан татвар	1,127,689.36	4,958,636.69
1100	Хувь хүний орлогын албан татвар	1,127,689.36	4,958,292.29
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	0.00	344.40
113	Хөрөнгийн албан татвар	73,591.60	288,025.93
118	Бусад татвар, төлбөр, хураамж	123,311.15	382,411.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,127,323.44	1,736,676.03
120	Нийтлэг татварын бус орлого	6,127,323.44	1,736,676.03
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	20,514,472.17	579,480.65
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	24,913,891.18	8,876,103.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	24,913,891.18	8,876,103.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,299,887.56	7,719,396.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	11,909,349.44	1,501,016.79
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,575,611.14	186,420.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,489,429.02	2,724,023.60
2104	Хангамж, бараа материалын зардал	279,639.05	62,724.81
2105	Нормативт зардал	577,736.85	5,160.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	166,261.40	237,926.03
2107	Томилот, зочны зардал	8,202.40	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	83,498.00	210,955.15
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,210,160.26	2,791,169.22
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,614,003.62	1,156,707.25
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	3,052,496.54	(930,872.76)

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	39,411.47	35,504,566.46
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	3,013,085.07	(36,435,439.21)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	18,302,625.49	6,741,402.48
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,324,592.11	5,629,073.82
110	Орлогын албан татвар	1,127,689.36	4,958,636.69
1100	Хувь хүний орлогын албан татвар	1,127,689.36	4,958,292.29
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	0.00	344.40
113	Хөрөнгийн албан татвар	73,591.60	288,025.93
118	Бусад татвар, төлбөр, хураамж	123,311.15	382,411.20
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	114,113.24	129,883.75
1181	Газрын төлбөр	9,197.91	252,277.45
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	0.00	250.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	619,267.85	532,848.01
120	Нийтлэг татварын бус орлого	619,267.85	532,848.01
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	16,358,765.53	579,480.65
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	17,870,634.64	6,392,567.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	17,870,634.64	6,392,567.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	17,400,052.03	5,235,626.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	11,912,461.32	1,501,016.79
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,581,781.37	186,420.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,378,737.69	2,719,673.60
2104	Хангамж, бараа материалын зардал	185,370.42	35,759.01
2105	Нормативт зардал	572,116.69	5,160.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	224,249.42	234,586.90
2107	Томилолт, зочны зардал	8,202.40	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	111,264.84	211,171.15
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	425,867.89	341,838.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	470,582.61	1,156,940.35
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	431,990.85	348,835.41
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	198,188.33	539,487.02
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	198,188.33	539,487.02
2200	Дотоод эх үүсвэрээр	198,188.33	539,487.02
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(198,188.33)	(539,487.02)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(22,310.00)	(149,000.00)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	22,310.00	149,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	211,492.52	(339,651.61)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	632,281.74	843,774.25
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	843,774.25	504,122.65

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгийн дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	50,867,799.45	50,867,799.45
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	7,769.78	7,769.78
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	50,875,569.23	50,875,569.23
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(2,347.94)	(2,347.94)
9	Тайлант үеийн үр дүн	3,013,085.07	3,013,085.07
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	53,886,306.36	53,886,306.36
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	53,886,306.36	53,886,306.36
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(325,746.12)	(325,746.12)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	53,560,560.24	53,560,560.24
19	Тайлант үеийн үр дүн	(36,435,439.21)	(36,435,439.21)
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	17,443,919.68	17,443,919.68

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,550,799.30	6,886,865.25	663,934.05	91.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,561,730.40	6,203,878.24	357,852.16	94.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,197,663.70	5,067,050.98	130,612.72	97.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,522,595.20	1,460,232.98	62,362.22	95.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	195,000.60	179,327.00	15,673.60	91.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,768,301.10	2,719,673.60	48,627.50	98.24
2104	Хангамж, бараа материалын зардал	28,258.60	27,807.81	450.79	98.40
2105	Нормативт зардал	3,000.00	3,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	221,517.40	221,446.10	71.30	99.97
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	214,450.90	212,394.10	2,056.80	99.04
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	244,539.90	243,169.41	1,370.49	99.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,364,066.70	1,136,827.25	227,239.45	83.34
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,317,196.30	1,090,000.00	227,196.30	82.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	46,870.40	46,827.25	43.15	99.91
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	689,068.90	533,987.02	155,081.88	77.49
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	300,000.00	149,000.00	151,000.00	49.67
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,550,799.30	6,777,313.10	773,486.20	89.76
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	6,488,794.40	6,512,690.35	-23,895.95	100.37
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,062,004.90	264,622.75	797,382.15	24.92

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	634.00	626.00	8.00	98.74
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.00	2.00	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	2.00	2.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	316.00	312.00	4.00	98.73
620001	Удирдах ажилтан	5.00	4.00	1.00	80.00
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	35.00	-18.00	205.88
620003	Үйлчлэх ажилтан	276.00	270.00	6.00	97.83
620004	Гэрээт ажилтан	18.00	3.00	15.00	16.67
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	316.00	312.00	4.00	98.73

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Т3 цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	193,963.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	193,963.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	174,075.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	40,783.81
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,093.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,951.20
2105	Нормативт зардал	2,160.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,440.80
2107	Томилолт, зочны зардал	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,977.05
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	98,669.47
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,887.66
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,880.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	7.66
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	193,963.39
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	193,963.39
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй, залруулагдаагүй нийт **1,643,862.4** мянган төгрөгийн зөрчил¹ илэрч зөрчил арилгуулах 2 албан шаардлага хүргүүллээ.

5.1 Албан шаардлага

5.1.1 Хоршоо хөгжүүлэх санд 170 зээлдэгчтэй холбоотой 710,750.3 мянган төгрөгийн 1-7 жилийн насжилттай хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4.11-т “Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ”, 11 зүйлийн 11.3-т “Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна.” гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

5.1.2 Сумын төсвийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэлээр 6 нэр төрлийн орлого 933,112.1 мянган төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23.8.14, 23.8.1, 41.2.1 “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Эрдэнэбулган сумын Засаг дарга нь тайлант хугацаанд шилэн дансны цахим системд нийт 154 мэдээллийг байршуулбал зохихоос 148 мэдээллийн хугацаанд нь мэдээлж, 6 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1-6.10 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.1 “Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ” гэсэн заалттай нийцэхгүй.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1-6.10-д заасан “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ ...” гэсэн заалтыг хэрэгжүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 11 дүгээр сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эрдэнэбулган сумын ТТЗ	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага Д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Эрдэнэбулган сумын ТТЗ	2	1,643,862.4	0	0	2	1,643,862.4	0	0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Эрдэнэбулган сумын ТТЗ	1	0	0	0		0		1	0			